



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар АБ4

Улаанбаатар хот

Бараа хүлээн авах комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "АТ-940 шалгалтын нислэгийн системийг агаарын хөлөгт суурилуулан хоршин ажиллуулахад шаардлагатай сэлбэг (Агаарын хөлгийн 3 хэмжээст байр зүйн тулгуур систем)" нийлүүлэх ИНЕГ/УЗ/24/2022 дугаартай гэрээний дагуу бараа хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:

Х.Гансүх

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн журам боловсруулалтын албаны шалгалтын нислэгийн хэсгийн дарга)

Гишүүд:

Г.Энхбаяр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нислэгийн журам боловсруулалтын албаны шалгалтын нислэгийн ахлах шалгагч инженер)

Э.Отгонбаяр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын тооцооны нягтлан бодогч)

Б.Энхтайван

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газрын нярав)

Нарийн бичгийн  
дарга:

Г.Хишигдэлгэр

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө

17120 0209

оруулалт, захиалагчийн албаны мэргэжилтэн)

2.Нийлүүлэх барааг техникийн тодорхойлолт, холбогдох баримт бичигт дурдсан шаардлагуудын дагуу шалган хүлээн авч, санхүүгийн бүртгэлд тусгуулан комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт, захиалагчийн албанд хүргүүлэхийг Бараа хүлээн авах комисс (Х.Гансүх)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА